

**ТӨМӨР ЗАМЫН СУУРЬ БҮТЦИЙН ГҮҮР БАРИХ
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2019.09.13.

Дугаар АГГ-19/197185/79 Улаанбаатар хот

ЭНЭХҮҮ ГЭРЭЭГ Монгол Улсын Иргэний хуулийн 189 дугаар зүйл, 343-358 дугаар зүйлд заасныг удирдлага болгон дор дурдсан талууд харилцан тохиролцож байгуулав.

Нэр	“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК (цаашид “Захиалагч” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Цэнгэл
Хаяг	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13 хороолол /14230/, Нарны зам-62 Юнион бюлдинг А блок 7 давхар
Нэр	“ГТЗ” ХХК, “ГАН ГҮҮР” ХХК, “ЧАЙНА СТЭЙТ КОНСТРАКШН” ХХК ТҮНШЛЭЛ (цаашид “Гүйцэтгэгч” гэх), түүнийг төлөөлж “Чайна стэйт констракшн монголиа” ХХК-ийн Захирал Ли Донг
Хаяг	Монгол Улс, Улаанбаатар, Баянгол дүүргийн 11 дүгээр хороо, Зүүн ард аюуш 1-2 тоот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын шугамын Зүүнбаян талаас 15 километр 57.32 уртааш метр гүүр барих ажил /цаашид “Ажил” гэх/-ыг Гүйцэтгэгч гүйцэтгэж Захиалагчид хүлээлгэн өгөх, Захиалагч нь тохиролцсон ажлын хөлсийг төлөхтэй холбоотой харилцааг зохицуулж, Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.

1.2. Энэхүү гэрээ нь энэ гэрээ болон гэрээний хавсралтуудаас бүрдэнэ.

Хавсралт-1: Компанийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл;

Хавсралт-2: Эрх бүхий байгууллагаар магадлагдсан гүүрийн зураг төсөл, ажлын тоо хэмжээ;

Хавсралт-3: Эрх бүхий байгууллагаар магадлагдсан гүүрийн ажлын жишиг төсөв;

Хавсралт-4: Техникийн шаардлага;

Хавсралт-5: Гүүр барих ажлын календарчилсан төлөвлөгөө;

Хавсралт-6: Ажлын гүйцэтгэлийг санхүүжүүлэх нөхцөл, санхүүжилтийн хуваарь;

Хавсралт-7: “ГТЗ” ХХК, “ГАН ГҮҮР” ХХК, “ЧАЙНА СТЭЙТ КОНСТРАКШН МОНГОЛИА” ХХК” түншлэлийг төлөөлж гэрээнд гарын үсэг зурах зөвшөөрөл олгосон шийдвэр;

Хавсралт 8: Гүүрийн ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулах баримт бичгийн загвар.

1.3. Гэрээ, түүний хавсралтууд болон тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд гэрээний хамт хүчин төгөлдөр болно.

Хоёр. Баталгаа

2.1. Захиалагч нь дараах баталгааг гаргаж байна. Үүнд:

2.1.1. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 121, 2013 оны 28 дугаар тогтоолоор тус тус Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод заасан I, II үе шатны төмөр замын суурь бүтцийг барих болон концессын эрхтэй болохыг;

2.1.2. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 135 дугаар тогтоолд заасан эх үүсвэрээс төвлөрүүлэх хөрөнгөөр энэхүү гэрээнд заасан санхүүжилтийг олгох;

2.1.3. Эрх бүхий байгууллагаар магадлагдсан гүүрийн зураг төслийг бэлэн болгохыг.

2.2. Гүйцэтгэгч нь дараах баталгааг гаргаж байна. Үүнд:

2.2.1. гэрээний дагуу ажил гүйцэтгэх, гэрээнээс үүсэх эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй, энэхүү гэрээг байгуулах, бүртгүүлэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай Тусгай зөвшөөрөл, эрхийг эрх бүхий байгууллагаас авсан, тэдгээр нь гэрээний үүргийг зохих ёсоор бүрэн гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр, гэрээнд заагдсан ажлыг гүйцэтгэх мэргэжлийн боловсон хүчин, санхүүгийн бүрэн чадамжтай гэдгийг;

2.2.2. Гүйцэтгэгч нь ажлыг Хууль тогтоомж болон энэ гэрээнд заасан шаардлагад нийцүүлэн, эрхийн болон биет байдлын доголдолгүй, холбогдох бичиг баримтын хамт үнэн зөв, иж бүрдэл бүрэн, гүйцэд хүлээлгэж өгнө гэдгийг;

2.2.3. Талууд энэхүү Гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан олж мэдсэн нөгөө талын үйл ажиллагаатай холбоотой нууц мэдээллийг тухайн талын зөвшөөрөлгүйгээр Хууль болон энэ гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй, энэхүү гэрээнээс үүссэн харилцаанаас өөр бусад зорилгоор ашиглахгүй байх.

Гурав. Хууль тогтоомж, гэрээг тайлбарлах

3.1. Талууд энэхүү гэрээг Монгол Улсын хууль тогтоомжид үндэслэн, эрх бүхий байгууллагаас баталсан аливаа дүрэм, журам, заавар, стандарт, шаардлагад нийцүүлэн Талуудын хоорондын эрх тэгш, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан байгуулав.

3.2. Гэрээний зүйл заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд хэрэв энэ гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын хуульд заасныг баримтална.

Дөрөв. Гэрээг байгуулсанд тооцох

4.1. Гэрээнд талуудын төлөөлөх эрхтэй этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

4.2. Гэрээг Монгол хэлээр хоёр хувь үйлдэх ба Гүйцэтгэгч, Захиалагч тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд эдгээр хууль зүйн адил хүчинтэй байна.

Тав. Гүйцэтгэх ажил, ажлын гүйцэтгэл

5.1. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний Хавсралт 2, 3, 4, 5-ын дагуу 57.32 уртааш метр гүүрийг барьж (цаашид "гүүрийн ажил" гэх) хүлээлгэн өгнө.

5.2. Гүүрийн ажлын үр дүн нь Хууль тогтоомж, холбогдох захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, заавар, үндэсний болон олон улсын стандартад нийцсэн байх бөгөөд Захиалагчийн өмч байна.

5.3. Гүйцэтгэгч гүүрийн ажлыг алдаатай, буруу хийснээс болж ажлын явцад ямар нэгэн ажлыг нэмж хийх шаардлага гарвал Гүйцэтгэгч өөрийн зардал, хөрөнгөөр засч, учирсан

хохирлыг барагдуулна.

5.4. Гүйцэтгэгч нь гүүрийн ажил гүйцэтгэх хугацаанд гүүрийн ажил гүйцэтгэхэд шаардлагатай бичиг баримтууд болон Захиалагчид шаардлагатай мэдээллийг бүрэн гаргаж өгнө.

5.5. Гүйцэтгэгч нь гүүрийн ажлын тодорхой хэсгийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох бөгөөд туслан гүйцэтгүүлэгчээр гүйцэтгүүлсэн ажлын үр дүнг захиалагчийн өмнө хариуцна.

5.6. Гүүрийн ажлын баталгаат хугацаа нь төмөр замын суурь бүтэц баригдаж ашиглалтад орсноос хойш 3 жил байна.

Зургаа. Ажил гүйцэтгэх хугацаа

6.1. Гүйцэтгэгч нь гүүрийн ажлыг энэхүү гэрээний хавсралт 5-д заасан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

6.2. Захиалагчийн шаардсан тухай бүрт Гүйцэтгэгч нь хийгдэж буй ажлын талаар мэдээлэл, тайланг хүргүүлнэ.

6.3. Гүйцэтгэгчийн ажлын зохион байгуулалт, үйл ажиллагаа, шаардлагатай техник тоног төхөөрөмжийг тээвэрлэхэд гарсан аливаа саатал, эрсдэл, санхүүгийн хүндрэл, энэ гэрээнд заасны дагуу ажлын гүйцэтгэлийн доголдлыг арилгасан зэрэг нь ажил гүйцэтгэх хугацааг зөрчих буюу хойшлуулах үндэслэл болохгүй.

6.4. Гүүрийн ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, эсхүл хугацаа хожимдуулж гүйцэтгэсэн нь Гүйцэтгэгчид захиалагчийн зүгээс энэ гэрээнд заасан алданги болон торгууль ногдуулах үндэслэл болно.

Долоо. Ажлын доголдлыг арилгах, гомдлын шаардлага гаргах

7.1. Гүйцэтгэгч нь гүүрийн ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, эсхүл Захиалагч, зохиогч, төрийн эрх бүхий хяналтын байгууллагын чиглэл, удирдамжийг зөрчиж гүйцэтгэсэн нь ажлын гүйцэтгэлийг хянах явцад болон энэ гэрээний гомдлын шаардлага гаргах хугацаанд илэрсэн бол уг зөрчлийг өөрийн хөрөнгөөр засч, доголдлыг арилгах, үүнээс үүсэн Захиалагч, гуравдагч этгээдэд учирсан хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй.

7.2. Гүйцэтгэгч ажлын үр дүнгийн доголдлын талаар санаатай нуун дарагдуулсан нь хожим илэрвэл тэрээр хариуцлагаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдөх үндэслэл болохгүй бөгөөд Захиалагч, гуравдагч этгээдэд учирсан шууд болон шууд бус хохирлыг бүрэн хариуцна.

Найм. Мэдээлэл солилцох, мэдээллээр хангах

8.1. Талуудын албан ёсны хаяг:

8.1.1. Захиалагч: "Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компани
Улсын бүртгэлийн дугаар: 9012001025
Регистрийн дугаар: 5214203
Хаяг: Юнион бюлдинг, А блок, 7 давхар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13 хороолол,
Нарны зам-62, Улаанбаатар /14230/
Утас: 7000-6622, 7010-6655,
Имэйл: info@mtz.mn

8.1.2. Гүйцэтгэгч: "ГТЗ" ХХК, "ГАН ГҮҮР" ХХК, "ЧАЙНА СТЭЙТ КОНСТРАКШН МОНГОЛИА" ХХК ТҮНШЛЭЛ"
"ЧАЙНА СТЭЙТ КОНСТРАКШН МОНГОЛИА" ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 9019084011
Регистрийн дугаар: 6159591



Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: “ГАН ГҮҮР” ХХК
2019/02/26 /РД:2066572, УБД:9011058001/

“Говийн төмөр зам” ХХК \РД:5969107, УБД: 9011543143\

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 11 хороо, Зүүн Ард Аюуш 1,2 тоот
Утас: 99998625, 99997988, 99115816
Имэйл: 105728898@qq.com

8.2. Гэрээний талууд үйл ажиллагаа эрхлэн явуулахад шаардлагатай мэдээллийг зөвхөн албан бичгээр харилцан солилцож байна.

8.3. Захиалагч талыг төлөөлж мэдээлэл солих ажилтан: Хиймэл байгууламжийн инженер Б.Төртулга. Холбоо барих утас: 80114378, и-мэйл хаяг: info@mtz.mn

8.4. Гүйцэтгэгч талыг төлөөлж мэдээлэл солих ажилтан: инженер Намдоржаа. Холбоо барих утас: 99998625, и-мэйл хаяг: 105728898@qq.com

8.5. Мэдээллийг бичгээр харилцахдаа факс, и-мэйл зэрэг цахим хэлбэрийг ашиглана.

8.6. Хойшлуулшгүй тохиолдолд Талууд мэдээллээ амаар болон утсаар солилцож болох боловч ийнхүү солилцсон мэдээллээ баталгаажуулж 48 цагийн дотор нөгөө талд бичгээр хүргүүлнэ.

8.7. Захиалагч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэдээ баримт, судалгаа, зааварчилгааг Гүйцэтгэгчийн хүсэлтийн дагуу ажлын 5 хоногийн гаргаж өгнө.

Ес. Ажил хүлээлцэх

9.1. Гүйцэтгэгч гүүрийн ажлын гүйцэтгэлийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу байгуулсан Улсын комиссын шийдвэрээр хүлээлцэнэ.

9.2. Улсын комиссын шийдвэр хүчин төгөлдөр болсны ажлын бичиг баримтыг акт үйлдэн хүлээлцэнэ.

9.3. Бичиг баримтыг хүлээлцэхдээ бичиг баримтын бүрдэл бүрэн гүйцэт, үнэн зөв эсэхийг шалган, Захиалагч бичиг баримтын эх хувийг хүлээн авна. Гүйцэтгэгч бичиг баримтын бүрдэл бүрэн гүйцэт, үнэн зөв эсэхийг хариуцан хүлээлгэн өгнө.

9.4. Гүйцэтгэгч өөрийн архивд авч үлдсэн хувиас шаардлагатай тохиолдолд Захиалагчийн хүсэлтийн дагуу үнэ төлбөргүй хуулбарлан авах боломжоор хангаж хуулбарыг баталгаажуулна.

Арав. Ажлын хөлс, төлбөр тооцоо

10.1. Энэхүү гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх ажлын хөлс нь 3,123,940,000 (гурван тэрбум нэг зуун хорин гурван сая есөн зуун ерэн дөрвөн мянга)-н төгрөг байна. Энэхүү үнэ гэрээний хугацаанд тогтмол байна.

10.2. Захиалагч тал төлбөрийн баталгааг дотоодын банкаар гаргуулж Гүйцэтгэгч талд өгөх бөгөөд гүүрийн ажлын хөлсийг гүйцэтгэлээр энэхүү гэрээний хавсралт 6-д заасны дагуу төлнө.

10.3. Гүйцэтгэгчээс захиалагчийн хяналтын инженерээр баталгаажуулж ирүүлсэн тайлан¹-г захиалагч хянан баталгаажуулсан /ажлын 5 хоногийн дотор/ баримт²-ыг үндэслэн төлбөрийг олгоно.

10.4. Ажлын хөлсийг Гүйцэтгэгчийн **Хаан банкны 5115060442** төгрөг Дансны нэр : “Чайна стэйт констракшн монголиа” ХХК-ийн данс руу шилжүүлнэ.

10.5. Ажлын хөлсөнд холбогдох НӨАТ, захиалагчийн болон зохигчийн хяналтын зардал,

¹ Энэхүү гэрээний Хавсралт 8-д заасан.

² Энэхүү гэрээний Хавсралт 8-д заасан.

холбогдох бүх төрлийн татвар, хураамж, үндсэн ажлын зардал, бусад холбогдох зардлууд бүгд багтсан болно.

10.6. Ажлын хөлс нь өөрчлөгдөхгүй, тогтвортой ба ажил гүйцэтгэх хугацаанд шаардлагатай үндсэн бараа, материал, түлшний үнэ өссөн зэрэг Захиалагчаас үл шалтгаалах байдлаар ажлын өртөг нэмэгдэхтэй холбогдсон эрсдэлийг Гүйцэтгэгч бүрэн хариуцна.

10.7. Захиалагч талаас өгсөн ажлын хамрах хүрээ, зураг төсөл алдаатай, өөрчлөгдсөний улмаас Гүйцэтгэгч талын ажил гүйцэтгэх зардал нэмэгдсэний дагуу энэхүү гэрээнд заасан ажлын хөлсийг нэмэгдүүлэх нөхцөл байдлыг бий болгосон бол Захиалагч тал нэмэгдэл төлбөрийг Гүйцэтгэгчтэй тохиролцон нэмэлт гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ.

10.8. Гэрээний үнийн 5 /тав/ хувийг Гүйцэтгэгч нь ажлын чанарын баталгаа болгон барьцаа хэлбэрээр үлдээх ба энэхүү гэрээний 5.6-д заасан хугацаанд Захиалагчийн дансанд үлдэнэ.

Арван нэг. Захиалагчийн эрх, үүрэг

11.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

11.2. Гүүрийн ажлын явцын тайланг Гүйцэтгэгчээс авах эрхтэй.

11.3. Гүйцэтгэгчийн гүйцэтгэж буй гүүрийн ажилд илэрсэн алдаа, зөрчлийн улмаас үүссэн аливаа хохирлыг нөхөн төлүүлэх, гүүрийн ажлын явц дахь гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас үүссэн бүх алдаа, зөрчлийг үнэ төлбөргүй дахин арилгуулах, засаж залруулах талаар шаардлага тавих эрхтэй.

11.4. Шаардлагатай тохиолдолд гүүрийн ажлын гүйцэтгэлд нарийн мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэх эрхтэй.

11.5. Захиалагч нь энэхүү гэрээнд заасны дагуу гэрээний төлбөрийг Гүйцэтгэгчид хугацаанд нь төлөх үүрэгтэй.

11.6. Гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгэхэд өөрсдийн зүгээс шаардлагатай туслалцааг Гүйцэтгэгч талд үзүүлэх үүрэгтэй.

11.7. Захиалагчийн зүгээс ажил хийж гүйцэтгэхтэй холбогдсон шаардлагатай, үнэн зөв мэдээ, мэдээллээр хангах үүрэгтэй.

11.8. Энэхүү гэрээ болон холбогдох хуульд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

Арван хоёр. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

12.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Захиалагчаас шаардах эрхтэй.

12.2. Гэрээнд заасны дагуу гэрээний төлбөрийг хүлээн авах эрхтэй.

12.3. Захиалагч талаас гаргаж өгөх ажлын хүрээн дэх мэдээ материалыг энэхүү гэрээнд заасан хугацаанд шаардан авах эрхтэй.

12.4. Гэрээнд заасан ажлыг хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, стандарт болон дүрэм журам, аргачлал, Захиалагчаас өгсөн зураг төсөл, техникийн шаардлагын дагуу гүйцэтгэн, улсын комисст хүлээлгэн өгөх үүрэгтэй.

12.5. Ажлын үр дүн, тайлан дүгнэлтэд тусгагдсан норматив болон тооцооны үзүүлэлтүүдийн үнэн зөвийг бүрэн хариуцах үүрэгтэй.

12.6. Гүүрийн ажилтай холбоотой алдаа, зөрчил болон техникийн шаардлага, зураг төслийн дагуу гүйцэтгэгдээгүй ажил бий болсон тохиолдолд Захиалагчид дахин үнэ төлбөргүйгээр засч өгөх, хохирлыг барагдуулах үүрэгтэй.

12.7. Гэрээний хугацаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бүхий л асуудлыг хариуцах үүрэгтэй.

12.8. Энэхүү гэрээний дагуу гүйцэтгэгчийн гүйцэтгэж буй ажилд гүүрийн зураг төсөл зохиогч болон захиалагч, хяналтын зөвлөхийг хяналт тавих боломжоор хангах үүрэгтэй.

12.9. Зохиогчийн болон захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй этгээд болон хяналтын

зөвлөхийн тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

12.10. Энэхүү гэрээ болон холбогдох хуульд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

Арван гурав. Нууцлал

13.1. Хууль болон гэрээнд зааснаас бусад тохиолдолд нөгөө Талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гэрээний талаарх аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.

Арван дөрөв. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах

14.1. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

14.2. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд нөгөө Талдаа саналаа бичгээр хүргүүлэх бөгөөд тухайн саналд нэмэлт, өөрчлөлтийн үндэслэл, түүний төслийг тусгана.

14.3. Саналыг хүлээн авсан тал ажлын 5 хоногийн дотор хариу ирүүлэх үүрэгтэй бөгөөд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.

14.4. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

Арван тав. Гэрээний зөрчлийг арилгах, гэрээ цуцлах

15.1. Талууд гэрээний үүргийн зөрчлийг арилгах тухай нөгөө талдаа бичгээр мэдэгдэл хүргүүлэх бөгөөд мэдэгдлийг хүлээн авсан тал гэрээний зөрчлийг ажлын 5 хоногийн дотор арилгаж хариу мэдэгдэх үүрэг хүлээнэ.

15.2. Хэрэв зөрчил гаргагч Тал зөрчлийг ажлын 5 хоногийн дотор арилгах боломжгүй бол энэ тухай нөгөө Талдаа мэдэгдэх бөгөөд зөрчил арилгах хугацааг Талууд харилцан тохиролцож тогтооно.

15.3. Талууд гэрээг цуцлах саналтай байгаа бол уг саналаа нөгөө Талд бичгээр хүргүүлж, харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

15.4. Захиалагч нь дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:

15.4.1. Гүйцэтгэгч энэ гэрээний дагуу ажил гүйцэтгэх хугацааг 10 буюу түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн;

15.4.2. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэхдээ чанарын ноцтой доголдол гаргасан бөгөөд захиалагч ажлыг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй гэж үзсэн;

15.4.3. Гүйцэтгэгч нь ажлын доголдлыг боломжит хугацаанд арилгаагүй, эсхүл ийнхүү арилгахаас зайлсхийсэн;

15.4.4. Гүйцэтгэгчийн баталгаа нь хуурамч болох нь илэрсэн;

15.4.5. Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн.

15.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:

15.5.1. Захиалагч төлбөрөө шилжүүлэх хугацааг 10 буюу түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн, цаашид шилжүүлэхгүй нь тодорхой болсон;

15.5.2. Захиалагч ажлын хамрах хүрээг өөрчилсөн нь энэхүү гэрээнд заасан ажлын хөлсийг нэмэгдүүлэх нөхцөл байдлыг бий болгосон бөгөөд захиалагч нэмэлт санхүүжилтийг гаргахаас үндэслэлгүйгээр татгалзсан;

15.5.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн.

15.6. Гэрээг цуцалсан тохиолдолд ийнхүү цуцалснаас хойш ажлын 3 хоногийн дотор гэрээ цуцалсан өдрөөр тасалбар болгон Захиалагч гуравдагч ажил гүйцэтгэгчээр ажлыг гүйцэтгүүлэх эрхтэй. Хэрэв гүйцэтгэгчийн зохих ёсоор гүйцэтгээгүй ажлыг гуравдагч ажил гүйцэтгэгч үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжтой тохиолдолд тухайн ажилд ногдох гүйцэтгэгчийн зардлыг захиалагч төлөх тохиолдолд гуравдагч ажил гүйцэтгэгчтэй зөвшилцсөнийг үндэслэн тооцно.

Арван зургаа. Хариуцлага

16.1. Гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө.

16.2. Захиалагч нь энэ гэрээнд заасан үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх хэмжээний алданги хүлээнэ.

16.3. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, гэрээнд заасны дагуу нэг талын санаачилгаар гэрээг цуцалсан бол буруутай тал нөгөө талд учруулсан аливаа хохирол болон зардлыг нөхөн төлнө.

16.4. Хэрэв аль нэг тал нь үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь шаардах эрхээ хэрэгжүүлээгүй бол энэ нь эрхээсээ татгалзсан гэж тооцохгүй бөгөөд эрхээ хожим хэрэгжүүлэх, шаардлагатай арга хэмжээ авахад саад болохгүй.

16.5. Аль нэг тал Гэрээгээр хүлээсэн үүргээ давагдашгүй хүчин зүйлийн улмаас зохих ёсоор биелүүлээгүй болох нь нотлогдвол үүрэг давагдашгүй хүчин зүйлийг арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно. Захиалагч төрийн эрх бүхий байгууллагаас хамааралтайгаар гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд саад учирсан тохиолдолд Захиалагчийн үүрэг тухайн нөхцөлийг арилах хүртэл хугацаагаар хойшилно.

16.6. Давагдашгүй хүчин зүйл гэж талуудын гэм буруутай болон болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалаагүй, тэдгээрийн хүсэл зориг, хяналтаас гадуур бий болсон, урьдчилан харах боломжгүй буюу зохих арга хэмжээг авсан ч сэргийлэх боломжгүй байсан, үүний улмаас Талуудын үүргийн гүйцэтгэлд саад учруулсан нөхцөл байдлыг хэлэх бөгөөд Захиалагчийг Гэрээний үүргээ биелүүлэх эсхүл төслийг үргэлжлүүлэх боломжгүй болгож буй Монгол улсын эрх бүхий байгууллагын шийдвэр, дүрэм, тушаал болон Монгол улсын бусад хууль, тогтоомж хамаарна.

Арван долоо. Маргаан шийдвэрлэх

17.1. Талууд харилцан хүндэтгэлтэй, бизнесийн ёс зүйг чанд сахиж, гэрээтэй холбоотой аливаа маргаан гарахаас урьдчилан сэргийлж ажиллана.

17.2. Энэхүү гэрээг тайлбарлах болон түүний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

17.3. Талууд харилцан тохиролцоонд хүрэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагчийг төлөөлж:

"Монголын төмөр зам" ТӨХК
Гүйцэтгэх захирал



Гүйцэтгэгчийг төлөөлж:

"Чайна стэйт констракшн монголиа" ХХК
Захирал

